

Эрүүл мэндийн газар

2024.10.02

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Магадлан итгэмжлэл, зөвлөн туслах үйлчилгээ:

ЭМС-ын 363 дугаар тушаалын дагуу ЭМЯ, ЭМХТ-тэй хамтран 2024 оны 7 дугаар сарын 18-24-ны хугацаанд 3 эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлийн ажлын байрны үнэлгээнд хамруулсан. Мөн Эрдэнэцагаан, Баяндэлгэр сумын ЭМТ, Энхлэн-Ачтан ӨЭМТ-үүдийн чанар, ХСХ, дотоод хяналтын багуудын үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.



2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх: ЭМСС-ын 2016 оны А/147 тоот тушаал АЗД-ын 2017 оны А/ 201 захирамжийн дагуу 2024 оны 8 сарын 28-29-ны өдрүүдэд Асгат, 9 сарын 11-13-ны өдрүүдэд Баяндэлгэр суманд явуулын үзлэгийг 6-8 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын баг нийт 1590 хүнд үзлэг хийж, **1711** хүнийг шинжилгээнд хамруулсан.



3. Зуны сувилал: Суурь өвчлөлтэй зорилтот бүлгийн хүүхдүүдийг томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлэгт давтан хэвтэлтийг багасгах байгалийн хүчин зүйлээр чийрэгжүүлэх зорилгоор АНЭ, УАУНЭ, 8 сумын эрүүл мэндийн төвүүд зуны сувилал ажиллуулж нийт 426 хүүхдийг хамруулсан.

4. Аян арга хэмжээ:

- **Цусны даралт ихсэлтийн аян-2024** аяны эхний өдөр буюу 7 сарын 31-ны өдөр "Цусны даралт ихсэлт, түүний хүндрэлээс сэргийлэх нь" сэдэвт 1.5 кредит сургалтыг нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн 60 эмч мэргэжилтэнд зохион байгуулсан. 2024.08.01-02-ны өдрүүдэд ЦДИ-ийн эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх үнэлгээг 40-с доош насны -292 иргэн ЗСӨ-өөр ойрын 10 жилд өвдөх

эрсдэлийг тогтоох үнэлгээг 40-с дээш насны-929 иргэн, Бие бялдрын бүрдмэл үнэлгээг-1151 иргэн, Эрүүл амьдралын хэв маяг сургалт, зөвлөгөөг-1151 иргэн Нийт 3523 иргэдэд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг урьдчилан сэргийлэх чиглэлээр үзүүлсэн.

- **“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад оношилгоог сайжруулъя”** аяныг 2024 оны 08 сарын 27- 09 сарын 27 хүртэлх хугацаанд нэг сарын хугацаатай зохион байгуулсан. Тус аяны хүрээнд “Оношилгоог зөв аюулгүй хийе” уриан дор 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр АНЭ, УАУНЭ чанарын өдөрлөг зохион байгуулж, туршлага солилцон өдөрлөгт эмч эмнэлгийн мэргэжилтэн 206, үйлчлүүлэгч 156 иргэн оролцсон.



- **Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлье”** -10 хоногийн аяныг 2024 оны 09 дүгээр сарын 17-ноос 27-ны хооронд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд ЭМБ-ууд нийт 53 заалттай төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
1. Өндөр эрсдэлтэй эм, Эмийн гаж нөлөө, Антибиотик эмийн хэрэглээний талаар мэдээлэл болон эмийн зохистой хэрэглээний сургалтыг цахим болон танхимаар давхардсан тоогоор 112 эмч, сувилагч, 32 эмнэлгийн ажилтан нийт 144 хүнд зохион байгууллаа.
 2. Амбулаториор болон хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч нарт давхардсан тоогоор 250 хүнд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт зохион байгуулж, 8 төрлийн боршур, 15 төрлийн 250 ширхэг гарын авлага, материал хэвлэн үйлчлүүлэгчдэд тарааж ажиллалаа.



5. **Тоног төхөөрөмжийн баталгаажуулалт:** ЭЭХХЗГ-аас баг 2024 оны 07 дугаар сарын 5-6-ны хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийлээ. Багаж тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгад АНЭ, Уулбаян, Түвшинширээ, Асгат, Наран, Онгон Энэрэлт ачтан, Энхлэн ачтан ӨЭМТ-үүд хамрагдлаа.



ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Эрүүл мэндийн салбарын 2025-2027 оны төсвийн төсөл, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд тушаасан.
- Орон нутгийн төсвийн 474,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Онгон сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар хийгдсэнээр стандартын шаардлага хангасан барилгад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж байна.



- Аймгийн засаг даргын Тамгын газраас зарласан "Уламжлалтын эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах" төсөл арга хэмжээний тендерт "Био Медикал инженеринг" ХХК шалгарч, 15 нэр төрлийн тоног төхөөрөмжийг гэрээний дагуу /32.330.000 төгрөг/ нийлүүлсэн.



- Монбиофарм ХХК-аас шууд гэрээгээр Элэгний В.С вирусийн түргэвчилсэн оношлуур 9000 ширхэг, МЭЙК “Баруун-Урт” ЭХНБ-аас нэг удаагийн бээлий 9000 ширхгийг татан авч, ЭМГ-ын даргын тушаалын дагуу ЭМБ-уудад олгосон. Улаан бурхан өвчний үед шаардлагатай “Томуугийн тээвэрлэх орчин”-г ХӨСҮТ-өөс 300 ширхгийг татан авч ЭМГ-ын даргын А/67 дугаар тушаалын дагуу ӨСЭМТ-үүдэд олгож хангалтыг хийн ажилласан. Улаан бурхан өвчний үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурын нөөцийн судалгааг өдөр бүр ЭЭХХЗГ-т 10 цагт ЭМБ-уудаас авч нэгтгэн хүргүүлж байна.

Автомашины парк шинэчлэл:

- Байгалийн олон янзын уур амьсгалд дасан зохицох төслийн 412,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Наран, Дарьганга сумдад
- 1. Улсын төсвийн 463,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүрэн тоноглогдсон MAN TGE 3.180 маркийн автомашин Аймгийн нэгдсэн эмнэлэгт
- 2. Иргэдийн 51,0 сая төгрөгийн хандивын хөрөнгөөр Хайсей, Приус-30 маркийн автомашин Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдад парк шинэчлэл хийгдэж, аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд автомашины хангалт 100 хувьд хүрсэн.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ:

- Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс шинээр зөвшөөрөл хүсэгч хоёр байгууллагад тусгай зөвшөөрөл олгож, нэг байгууллагын хугацааг сунгаж, байршил солигдсон хоёр байгууллагын хүсэлтийг шийдвэрлэсэн.

ТАЙЛАН МЭДЭЭ:

- МУ-н ерөнхийлөгчийн 73-р зарлиг ҮАБЗ-г мэдээллээр хангах журмын дагуу өдөр бүрийн 08:30 цагт эрүүл мэндийн мэдээллийг дээд шатны байгууллагад нэгтгэн хүргүүлж байна.
- Томуугийн харуулдан тандалтын 7 хоног бүрийн мэдээг 12 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгээс авч нэгтгэн хугацаанд нь ХӨСҮТ-д 13 удаа мэдээлсэн.
- Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүрийн 05-ны дотор цахим системээр аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ:

1. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/13 тоот Шүдний эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний байдалд урьдчилан

сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Цагаан хүч” ХХК-ний Цагаан алт шүдний эмнэлэг, “Тунгалаг аман хужир” ХХК-ний Аман хужир шүдний эмнэлэг, “Бэсү” ХХК-ний Бэсү шүдний эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2024 оны 09 дүгээр сарын 10-20-ны өдрүүдэд зохион байгуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 45 заалттай 3 албан шаардлага хүргүүлж, 2 иргэнд тус бүр 100 000 төгрөгийн торгууль шийтгэврийн арга хэмжээ авсан.

2. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх 03/00/13 тоот удирдамжийн хүрээнд Баруун-Урт сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг 4-н сургууль, 11 цэцэрлэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, аймгийн хэмжээний 42 боловсролын байгууллагын ундны усны 84 дээжид хими судлалын 462 үзүүлэлтээр, нян судлалын 58 үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэхээр дээж цуглуулан аймгийн СХЗХэлтсийн нэгдсэн лабораторид хүлээлгэн өгсөн.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Дархлаажуулалтын тухай хууль, Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаалаар хийгддэг 3 төрлийн дархлаажуулалтын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдлага, арга зүйгээр ханган ажилласан.

- Дархлаажуулалтын тухай хууль, Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоол, ЭМС-ын 2001 оны 34 тоот тушаалын дагуу тархвар судлалын заалтаар хийгддэг тарваган тахал өвчний эсрэг вакцинаар ОБГ, Зэвсэгт хүчний 338-р анги, АНЭ, Цагдаагийн газрын нийт 137 ажилтан, албан хаагчдыг дархлаажуулан, дархлаажуулалтын дараах хэсэг газрын урвал илэрсэн 38 хүнд, тандалт судалгаа хийсэн.
- Аймгийн хэмжээнд Улаанбурханы вакцинд хамрагдвал зохих нийт 675 ажилтнаас эмч 171, сувилагч 239, бусад ажилтан 265 байхаас Улаанбурханы өвчний эсрэг вакцинд хамрагдсан 613/91%-ийн хамралттай байна.
- ЭМС-ын 2024 оны А/359 дүгээр тушаал, Эрүүл мэндийн газрын даргын А/73 дугаар “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” тушаалаар аймгийн хэмжээнд дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулан, томуугийн вакцинд эрсдэлт бүлгийн хүн ам буюу жирэмсэн эмэгтэй, архаг хууч өвчтэй хүн, 65-аас дээш насныхан, эрүүл мэндийн байгууллагын ажилчид, 6 сараас 5 хүртэлх насны хүүхдүүдийг томуугийн эсрэг вакцинаар 3859/89% дархлаажуулан ажиллаж байна. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илрээгүй.
- ЭМС-ын 2024 оны 8 дугаар сарын А/344 тоот тушаалын дагуу улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг улсын хэмжээнд зохион байгуулан 0-18 хүртэлх насны хүүхдүүдийн дархлаажуулалтын цахим

бүртгэлийг эргэмжээр программд оруулан Аймгийн хэмжээнд 7080 хүүхдийн товллын болон нэмэлт дархлаажуулалтын мэдээллийг шивээд байна.



Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлын менежмент: Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр төр хувийн хэвшлийн 10 эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт хийсэн. Цаашид аймгийн хэмжээнд хэлэлцүүлэг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА:

Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудыг тогтмол, үе шаттайгаар холбогдох байгууллагуудтай хамтран танхимын сургалтыг 12 удаа, цахим сургалтыг 8 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 570 эмч эмнэлгийн мэргэжилтэн, 510 сурагч, албан хаагч, 1151 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан байна.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудсанд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 548 удаагийн зураг, контент, видео, яриа, зөвлөмж байршуулан ажилласан. Нэг мэдээлэлд дунджаар 3100 орчим иргэний хандалт авсан байна.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр бага насны хүүхдийн цогц хөгжил ТТБ-тай хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтэн, СӨБ-ын арга зүйч, насан туршийн суралцахуйн төвийн багш нарт “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих эцэг эх асран хамгаалагч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж орон нутгийн 31 сурагч багшийг бэлтгэсэн.

Сүхбаатарын өнгө сонинд Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, улаанбурхан өвчний дархлаажуулалтын талаар мэдээлэл хэвлүүлсэн. Сүхбаатар аймгийн 13 сумын 65 багт сонин тараагдан ард иргэдэд хүрсэн байна.

Сумдын эрүүл мэндийн төвүүдтэй хамтран үүрэн телефоны операторуудаар дамжуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 1879 иргэнд масс мессежийг хүргэн ажилласан.



- **Эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажлын байрны сургалт:**
ЭМГ, АНЭ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу анхан шатны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байрны дадлага, сургалтад хамруулав. Хүүхдийн тасагт 5 их эмч, төрөх тасагт 3 их эмч, мөн УАУ-ны чиглэлээр 21 эмч, сувилагч хамрагдсан.



Тайланг нэгтгэсэн: ХШҮДАХ мэргэжилтэн Д.Саранзаяа